



ҮНДСЭН НӨХЦӨЛ

ГЭРЭЭНИЙ ДУГААР:
ГЭРЭЭНИЙ ТӨРӨЛ:

ДААТГАГЧИЙН НЭР, ХАЯГ:

Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал

ДААТГАЛЫН ГЭРЭЭ
БАЙГУУЛАГЧИЙН НЭР, ХАЯГ:

Шүүхийн ерөнхий зөвлөл
Хаяг: 211238, Улаанбаатар хот,
Чингэлтэй
дүүрэг, 5-р хороо, Тасганы овоо,
Хувьсгалын зам-22, Шүүхийн
Ерөнхий зөвлөлийн байр Утас: 976-
77104949

ДААТГАЛЫН ЗҮЙЛ:

Гэрээний хавсралтад заасан анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн амь нас, эрүүл мэнд.

ДААТГАЛЫН ХУГАЦАА:

2024 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн 1 жил буюу 12 сар

ДААТГУУЛАГЧИЙН ӨӨРИЙН
ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:

Өөрийн хүлээх хариуцлага байхгүй

ДААТГУУЛАГЧ НЭМЭХ:

Даатгуулагчийн албан мэдэгдлийн дагуу гэрээнд нэмж хавсаргана.

ДААТГАЛЫН НИЙТ ҮНЭЛГЭЭ:

Нийт шүүгчийн сүүлийн 15 жилийн цалингийн хэмжээ

ДААТГАЛЫН НИЙТ ХУРААМЖ:

1.540.000.000 төгрөг

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТАД:

Шүүгчийн овог нэр, даатгалын дугаар, албан тушаалын мэдээллийг хавсаргасан байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ: ҮЙЛЧЛЭХ НУТАГ
ДЭВСГЭР:

Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэр

ШҮҮГЧИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ гэрээгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн амь нас эрсдэх, эрүүл мэндэд бэртэл гэмтэл учирсан болон хохирол учруулсан нөхцөлд даатгагч нь даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн төлөх, даатгалын гэрээ байгуулагч нь даатгалын хураамж төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Талууд энэ гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 1.3. Энэ гэрээг Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын оны дүгээр тушаалаар байгуулагдсан "Даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгох чиг үүрэг бүхий Үнэлгээний хороо"-ны оны дугаар сарын-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, түүнээс гарсан санал, дүгнэлтэд үндэслэн байгуулсан болно.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэ гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1 "даатгагч" гэж Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ашгийн төлөө компанийг,
 - 2.1.2 "даатгуулагч" гэж анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчдийг;
 - 2.1.3 "даатгалын гэрээ байгуулагч" гэж шүүгчдийн амь нас, эрүүл мэндийг даатгуулан даатгалын хураамж төлж, гэрээ байгуулагч Шүүхийн ерөнхий зөвлөлийг;
 - 2.1.4 "даатгалын эрсдэл" гэдэгт даатгуулагчид хохирол учруулж болохуйц гэрээгээр тохирсон нөхцөл, үйлдэл, орчин, үйл явдлыг;
 - 2.1.5 "даатгалын тохиолдол" гэдэгт даатгуулагчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;
 - 2.1.6 "даатгалын хураамж" гэж даатгуулагчийн амь нас, эрүүл мэндийг даатгуулсны төлөө даатгагчид төлөх мөнгөн хөрөнгийг;
 - 2.1.7 "даатгалын нөхөн төлбөр" гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;
 - 2.1.8 "даатгалын үнэлгээ" гэж даатгуулагчийн даатгуулсан хэмжээний мөнгөн илэрхийллийг;
 - 2.1.9 "гэнэтийн осол" гэдэгт хүлээгдэж байгаагүй, гэнэтийн гаднын шинж чанартай хүчин зүйлийн шууд үр дүнд даатгуулагчийн амь нас болон бие эрхтний гэмтэл, өвчлөлд хүргэх ослыг;
 - 2.1.10 "гэнэтийн өвчлөл" гэж хүлээгдэж байгаагүй, эрүүл мэндэд хохирол учруулахуйц гэнэтийн шинж чанартай өвчин болон архаг хууч өвчний сэдэрлтийг;
 - 2.1.11 "даатгуулагч албан үүргээ гүйцэтгэх" гэдгийг ажлын болон ажлын бус цагаар, шүүн таслах ажиллагаа эрхлэх, албан томилолтоор ажиллах, ажлын байрандаа амрах, ажилдаа ирэх, буцах замд аливаа тээврийн хэрэгслээр буюу явган явж байх үед болон шүүхээс зохион байгуулсан арга хэмжээнд оролцох эсхүл эдгээртэй адилтгах бүхий л албан ажлуудыг хамруулан ойлгоно.

ГУРАВ. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

- 3.1 Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчдийн амь нас, эрүүл мэнд нь даатгалын зүйл байна. Гэрээний хавсралтад шүүгчийн нэр, даатгалын дугаар, албан тушаалын мэдээллийг хавсаргана.
- 3.2 Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгч шинээр томилогдсон өдрөөс хойш талууд гэрээ, гэрээний хавсралтад ажлын 5 өдрийн дотор холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна.
- 3.3 Хавсралт хуудас, гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг байна.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ

- 4.1 Даатгуулагч албан үүргээ гүйцэтгэх явцад, албан үүргээ гүйцэтгэсэнтэй холбоотойгоор учирсан болон бусад бүх хугацаанд /24 цагаар/ үүссэн дараах эрсдэлийг даатгалын үндсэн эрсдэлд тооцов. Үүнд:
 - 4.1.1 Байгалийн эрсдэл:
 - хүчит салхи, цасан ба шороон шуурга, цочир хүйтрэлт, үер усны аюул, газар хөдлөлт, хөрсний нуралт, гулгалт, цөмрөлт;
 - аянга, гал түймэр, дэлбэрэлт зэрэг эрсдэл;
 - 4.1.2 Ахуйн эрсдэл:
 - элдэв зүйлд цохиулах, хавчигдах, хавчуулах, унах, түлэгдэх, хөлдөх, осгох;
 - наранд цохиулах, угаартах, хорт хий, химийн бодис, эмийн зүйл, ургамалд хордох, амьтан, шавжид хазуулах, дайралт болон зам тээврийн аюул осолд өртөх зэрэг эрсдэл;
 - 4.1.3 Мал, амьтдын нөлөөгөөр үүсэх эрсдэл:
 - морь малаас унах, чирэгдэх, малд дайруулах, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах тэрчлэн мал амьтан, араатан амьтан, нохойд уруулах, бариулах зэрэг эрсдэл;
 - 4.1.4 Техниктэй харьцах үеийн эрсдэл:
 - автомашин, мотоцикл, унадаг дугуй зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл, төмөр зам, агаарын болон усан замын тээврийн хэрэгсэл жолоодох түүгээр зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, шүргэлцэх, шарвах, унах, живэх зэрэг ослоос үүдэлтэй эдгээртэй адилтгах бусад эрсдэл;
 - 4.1.5 Ажил үүргээ гүйцэтгэж байх үеийн буюу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1- 47.2.3 дахь заалтад заасан осол, эрүүл мэндэд учирсан хохирол, тэдгээрээс үүдэлтэй эрсдэл;
 - 4.1.6 Гуравдагч этгээдээс учруулах эрсдэл;
 - 4.1.7 Бусдад хорлогдох, зодуулах, буу, хутга мэс зэрэг зэвсэгт болон гаднын дайралтад өртөх зэрэг эрсдэл;
 - 4.1.8 Цацраг идэвхт болон химийн хорт бодисын нөлөөлөл, биологийн гаралтай өвчин үүсгэгчийн гэнэтийн аюулд өртсөн;
 - 4.1.9 Гэнэтийн өвчлөл:
 - Мухар олгойн хурц түгжрэл болон түүний архаг өрөвслийн сэдрэлт;
 - Гэдэсний хурц түгжрэл;
 - Хоол боловсруулах эрхтний цооролт, түлэгдэлт;
 - Цус харвалт;
 - Ухаан алдалт, зүрхний цусан хангамж алдагдах болон цус багадалтаас үүдэлтэй зүрх хаагдах, зүрхний цочмог шигдээс;
 - Тархины цусан хангамж багасах, тархины судасны хатуурал, тархины хаван үүсэх;
 - Үе мөчний бүх төрлийн өвчин;
 - Гэнэтийн ухаан алдалт;
 - Татаж унах;
 - Хордолт;
 - Бүх төрлийн хордлого, хордлогын халдвар;
 - Хүн, малын гоц халдварт өвчин, Ковид - 19 болон бусад халдварт өвчин;

- Архаг хууч өвчин сэдрэлт;
 - Хортой болон хоргүй хавдрын оноштой;
 - чихрийн шижин буюу сахарын өвчлөлийн улмаас шоконд орох, мэс ажилбарт орох, гар, хөл тайруулах, хараа гэмтэх, хараагүй болох;
 - мал амьтанд мөргүүлэх;
 - Бусад гэнэтийн өвчлөлтүүд.
- 4.2 Нэмэлт хамгаалалт
- 4.2.1 Шүүгч гадаад улс оронд албан томилолтоор ажиллах /сургалт, семинар, айлчлал, хэлэлцээр гэх мэт/ үед шүүгчийн амь нас, эрүүл мэндэд учирсан эрсдэл мөн адил хамаарна. Нэг шүүгчийн гадаад зорчигчийн даатгалын үнэлгээ 50,000 ам.доллар байх бөгөөд зохих даатгалын хураамжийг даатгагч хариуцна. Томилолтоор ажиллах шүүгчийн овог нэр, регистерийн дугаар, гадаад паспортыг дугаар, зорчих улс, зорчих хугацааг даатгагчид 14 хоногийн өмнө бичгээр эсвэл мэйлээр мэдэгднэ.
- 4.2.2 Олон нийтийг хамарсан,вакцинжуулалтыг зайлшгүй хийлгэхийг шаардсан /Ковид 19 тархсантай ижил нөхцөл байдал/ өвчлөлөөр өвдөх эрсдэл. Нөхөн төлбөр олгох дээд хэмжээ гэрээний хугацаанд нийтдээ нэг шүүгчийн хувьд 200,000 төгрөг байна. Эмчийн заалт, болон хүндэтгэн үзэх шалтгаанаар вакцинд хамрагдаагүй тохиолдолд үүнийг нотолсон бол энэхүү эрсдэлээс хамгаалагдана.
- 4.2.3 Энэхүү гэрээний 4.2.2-т заасан эрсдлийг сонгосон тохиолдолд даатгуулагч нэмэлт хураамж төлөхгүй.

ТАВ. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

- 5.1. Нэг шүүгчийн сүүлийн 15 жилийн цалингийн хэмжээ 424,924,404-467,961,828 төгрөг
- 5.2 Нэг шүүгчийн сүүлийн 3 жилийн цалингийн хэмжээ 111,294,000-123,660,000 төгрөг
- 5.3 Нэг шүүгчийн сүүлийн нэг жилийн цалингийн хэмжээ 46,494,000-51,660,000 төгрөг
- 5.4 Нийт шүүгчийн тоо: 550-580 шүүгч
- 5.5 Нийт шүүгчийн даатгалын үнэлгээ: нийт шүүгчийн сүүлийн 15 жилийн цалингийн хэмжээ
- 5.6 Жилийн хураамж: 1.540.000.000 төгрөг
- 5.7 Даатгалын хураамжийг гэрээ байгуулагч талын санхүүжилт шийдвэрлэгдсэн даруй албан бичгээр мэдэгдэж, даатгагчаас ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн ажлын 10 өдрийн дотор шуурхай шилжүүлнэ.
- 5.8 Даатгагч даатгалын нэг жилийн хураамжаас үлдсэн хэмжээнээс 5 хувьтай тэнцэх хэмжээгээр даатгуулагчдад гадаад болон дотоодын эрүүл мэндийн байгууллагад оношилгоо, эмчилгээ хийлгэх, эрүүл мэндийн сэтгэл зүйн нэмэлт үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

ЗУРГАА. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- 6.1 Даатгалын тохиолдол бүрдсэн нөхцөлд даатгуулагчид нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь энэ гэрээ болон Даатгалын тухай хууль, Иргэний хуулиар зохицуулагдана.
- 6.2. Даатгагч нь нөхөн төлбөрийг даатгуулагчид дараах байдлаар олгоно. Үүнд:
- 6.2.1. Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсан:
Даатгуулагч энэ гэрээнд заасан даатгалын эрсдэлийн улмаас түр хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдвал эмнэлэгт хэвтсэн, амбулатори, гэрээр эмчлүүлсэн хугацаанаас хамааруулан дараах хувиар нөхөн төлбөрийг олгоно.

Нөхөн төлбөрийн хэмжээ	
Хөдөлмөрийн чадвараа түр алдах /ажлын өдрийн хоногоор/	Тухайн шүүгчийн сүүлийн нэг жилийн цалинтай тэнцэх хэмжээнээс дараах хувь хэмжээгээр тооцно.
1-15	0,7% /нэг өдрийн/
16-30	15%
31-45	20%
46-60	25%
61-75	30%
76-90	40%

Жич: Хөдөлмөрийн чадваргүй байсан хугацааг ажлын өдрөөр тооцно.

6.2.2. Даатгуулагч удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдах болон бүрмөсөн алдсан тохиолдолд дараах хувь хэмжээгээр нөхөн олговрыг олгоно.

- хөдөлмөрийн чадвараа 30 хүртэл хувиар алдсан нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн 3 жилийн цалингийн үнэлгээний 30 хувиар;
- хөдөлмөрийн чадвараа 31-50 хүртэл хувиар алдсан нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн 3 жилийн цалингийн үнэлгээний 50 хувиар;
- хөдөлмөрийн чадвараа 51-60 хүртэл хувиар алдсан нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн 3 жилийн цалингийн үнэлгээний 60 хувиар;
- хөдөлмөрийн чадвараа 61-70 хүртэл хувиар алдсан нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн 3 жилийн цалингийн үнэлгээний 70 хувиар;
- хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан тохиолдолд тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалингийн үнэлгээний 100 хувиар;
- хөдөлмөрийн чадвараа алдан цаашид мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж чадахааргүй болсон нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалинтай тэнцэх хэмжээгээр.

6.2.3 Даатгуулагч нас барсан

-Даатгуулагч гэрээнд заасан эрсдэлийн улмаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа нас барсан тохиолдолд сүүлийн 15 жилийн цалинтай тэнцэх хэмжээгээр буюу даатгалын үнэлгээний 100 хувиар түүний өв залгамжлагчид нөхөн төлбөрийг олгоно.

6.3 Даатгалын нөхөн төлбөртэй холбоотой баримт материалыг даатгагчид бүрдүүлж өгөх хугацаа:

6.3.1 Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсан өдрөөс хойш ажлын 21 өдрийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөлд, Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээж авснаас хойш ажлын 5 өдрийн дотор;

6.3.2 Даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоосноос хойш 30 өдрийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөлд, Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор;

6.3.3 Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд 4 сарын дотор. Даатгуулагч хүндэтгэн үзэх шалтгаантай байснаа нотолно.

6.4 Даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэхэд бүрдүүлэх бичиг баримт:

6.4.1 Өргөдөл

6.4.2 Хөдөлмөрийн чадвар түр алдалтын үед эмнэлгийн хуудас, эмнэлгийн магадалгаа, амбулаторийн карт, эмнэлгийн хуудас олгогдохгүй даатгуулагчийн хувьд эмнэлгийн магадалгаа, амбулаторийн карт, рентген зураг;

6.4.3 Хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн буюу бүрмөсөн алдсан тохиолдолд эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;

6.4.4 Шаардлагатай бусад баримт бичиг, замын цагдаа, гал түймэр, шүүх прокурор, мөрдөн байцаах болон шүүх эмнэлгийн байгууллагаас авсан баримт, нотолгоо, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн тохиолдолд энэ тухай шийдвэр;

- 6.4.5 Эмнэлгийн хуудас нь "эмнэлгийн хуудас олгох журам"-д нийцсэн байна. Амбулаторийн карт нь уг гэмтэл бэртлийн эмчилгээний бичилттэй байна.
- 6.5 Даатгалын нөхөн төлбөрийг шийдвэрлэх:
 - 6.5.1 Даатгагч нөхөн төлбөрийн талаарх шаардлага хангасан баримт бичгүүдийг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор шийдвэрлэнэ.
 - 6.5.2 Даатгагч нөхөн төлбөртэй холбоотой нэмэлт баримт бичиг, тодруулга шаардлагатай тохиолдолд дээрх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.
 - 6.5.3 Даатгагч энэ гэрээний 6.3.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш даатгуулагчаас ирүүлсэн нөхөн төлбөртэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээж авахгүй.
 - 6.5.4 Даатгуулагч нь энэ гэрээний 6.2-т заасан тохиолдлоор даатгалын нөхөн төлбөр авсан нь дахин энэ гэрээнд заасан тухайн болон өөр даатгалын эрсдэлээр нөхөн төлбөр авах эрхийг хязгаарлахгүй.
 - 6.5.5 Даатгуулагч бусад хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын дагуу нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын сангаас олгогдох тэтгэвэр тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авсан нь энэхүү гэрээний дагуу нөхөн төлбөр авахад саад болохгүй;

ДОЛОО.НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛ

- 7.1 Даатгагч дараах тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй. Үүнд:
 - 7.1.1 Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;
 - 7.1.2 Даатгуулагч даатгалын зүйлийн талаар худал мэдээлсэн, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
 - 7.1.3 Даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;
 - 7.1.4 Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
 - 7.1.5 Санаатайгаар амиа хорлосон эсхүл хорлохыг завдсан;
 - 7.1.6 Гэнэтийн осол аюулаас бусад шалтгаанаар үр зулбах, үр хөндүүлэх, жирэмслэлт, хүүхэд төрүүлэхтэй холбогдсон осол гэмтэл;
 - 7.1.7 Даатгуулагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;
 - 7.1.8 Ан хийх үед гарсан осол гэмтэл;
 - 7.1.9 Мэргэжлийн тэмцээн, уралдаанд оролцсоны улмаас үүссэн осол гэмтэл;
 - 7.1.10 Даатгуулагч гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр завдсан бөгөөд түүний хор уршгийн улмаас даатгалын тохиолдол бүрдсэн;
 - 7.1.11.Даатгуулагч согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ осолдож гэмтсэн буюу тээврийн хэрэгслийг жолоодсон, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн болон жолоодох эрхгүй хүнд жолоогоо дур мэдэн дамжуулсны улмаас даатгалын тохиолдол бүрдсэн.

НАЙМ.ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 8.1 Даатгуулагчийг төлөөлж даатгалын гэрээ байгуулагчийн эрх:
 - 8.1.1 Даатгалын тохиолдол үүссэн үед нөхөн төлбөрийг тогтоосон журмын дагуу даатгагчаас гаргуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, учирсан хохирлыг нэхэмжлэх;
 - 8.1.2 Гэрээтэй холбоотой тайлбар зөвлөгөө авах;
 - 8.1.3 Даатгагч нь хууль болон энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу даатгалын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хууль ёсоор аваагүй нь тогтоогдвол гэрээг цуцлах болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардах;
- 8.2 Даатгуулагчийг төлөөлж даатгалын гэрээ байгуулагчийн үүрэг:
 - 8.2.1.Даатгалын тохиолдол үүссэн үед ажлын 5 өдрийн дотор даатгагчид мэдэгдэх, энэ хугацаанд мэдэгдэх боломжгүй байсан бол түүнийг нотолсон баримт, материалыг авчрах;
 - 8.2.2. Шүүгчийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын

- тохиолдол гарсан үед хохирлыг багасгах зорилгоор шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;
- 8.2.3. Даатгалтай холбогдсон баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх;
 - 8.2.4. Даатгагчид эрсдэлийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг өгөх;
 - 8.2.5. Даатгалын хураамжийг хууль, гэрээгээр тогтоосон хугацаанд бүрэн төлөх;
 - 8.2.6. Энэ гэрээнд заасны дагуу даатгагчаас гарсан зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэн авахад шаардлагатай туслалцааг үзүүлэх;
 - 8.2.7. Даатгуулагч нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан нөхөн төлбөртэй холбоотой бичиг баримтыг гэрээнд заасан хугацаанд даатгагчид бүрдүүлж өгөх.
- 8.3 Даатгагчийн эрх:
- 8.3.1 Даатгуулагчийн өгсөн мэдээ, материалын үнэн зөв эсэхийг шалгах, шаардлагатай бол эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандах;
 - 8.3.2 Даатгалын тохиолдол болсон газартай танилцах, шаардлагатай гэж үзвэл хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагын туслалцаа авах;
 - 8.3.3 Даатгуулагчийг төлөөлж гэрээ байгуулсан этгээд эрх, үүргээ өөр этгээдэд шилжүүлсэн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар эрх шилжүүлэн авсан этгээдтэй хэлэлцээр хийх;
 - 8.3.4 Даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
 - 8.3.5 Даатгуулагчийн ажиллах орчин, ажлын нөхцөлтэй газар дээр нь очиж танилцах;
- 8.4 Даатгагчийн үүрэг:
- 8.4.1 Даатгуулагчид даатгалтай холбогдолтой хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг танилцуулж, даатгалын баталгааг даатгуулагчид гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор бичиж олгох. Энэ үүргээ гүйцэтгээгүй нь даатгуулагчийг даатгалын материал бүрдүүлж өгөх хугацааг хоцроосон гэх үндэслэл болохгүй;
 - 8.4.2 Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тодорхой зааж, ажлын 5 өдрийн дотор даатгуулагчид болон Шүүхийн ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ. Ингэж мэдэгдээгүй бол нөхөн төлбөр олгохоос татгалзах үндэслэл болохгүй;
 - 8.4.3 Даатгуулагчийн хувийн, эмзэг, эрүүл мэндийн мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах, мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахгүй байх;
 - 8.4.4 Даатгалын тохиолдол бий болсон үед даатгуулагчид нөхөн төлбөрийг гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;
 - 8.4.5 Даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгалын нөхөн төлбөр дээр нэмж оруулан даатгуулагчид төлөх;
 - 8.4.6 Даатгалын нөхөн төлбөр олголтын талаарх мэдээг сар бүрийн 1-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлнэ;
 - 8.4.7 Даатгуулагчдад даатгалын эрсдэлийн ямар тохиолдолд нөхөн төлбөр нэхэмжлэх, олгох талаар сургалт, мэдээллийг гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор хийх;
 - 8.4.8 Шинээр шүүгч томилогдсон үед тухайн шүүгчтэй уг гэрээний дагуу гэрээ байгуулж даатгалд хамруулах.

ЕС.ГЭРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 9.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 9.2 Даатгагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хугацаа хэтэрсэн хоног тутамд төлнө.

АРАВ.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- 10.1 Энэ гэрээнд талууд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 10.2 Гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно.
 - 10.2.1 Гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;
 - 10.2.2 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
 - 10.2.3 Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;
 - 10.2.4 Даатгагч төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан;
 - 10.2.5 Хуульд заасан бусад үндэслэл.
- 10.3 Гэрээнд заасан хугацаанаас өмнө талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талын санаачилгаар гэрээг цуцалж болно. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах саналтай бол энэ тухайгаа нөгөө талдаа 1 сарын өмнө бичгээр мэдэгдсэн байна.
- 10.4 Даатгагчийн буруугаас гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахад хүрвэл даатгалын гэрээ байгуулагчийн төлсөн хураамжийг бүрэн хэмжээгээр, гэрээ байгуулагчийн буруугаас цуцалбал үлдсэн хугацаанд ногдох хураамжаас даатгалтай холбогдон гарсан зардлыг хасаж, үлдэх хэсгийг тус тус эргүүлэн олгоно.

АРАВ НЭГ.ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

- 11.1 Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал болон талуудын ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай даатгагч, даатгуулагчийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээлэл, даатгалын хэмжээ, төлбөр тооцоо, бусад үзүүлэлтүүд, байгууллага хувь хүний нууц, ноу-хауг хугацаагүй хадгална.
- 11.2 Гэрээнд зааснаас бусад асуудлаар талууд өөр хоорондын ашиг сонирхлыг хөндсөн хөндлөнгийн аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.
- 11.3 Гэрээний нууцлалыг аливаа хэлбэрээр шууд болон шууд бусаар бусдад задруулсан, дамжуулсан тохиолдолд түүнтэй холбоотой үүссэн хохирлыг нөгөө тал бүрэн барагдуулна. Даатгагч гэрээний нууцлалыг задруулсан тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс даатгалтай холбоотой асуудлаар зарласан тендерт дахин оролцох эрхээ бүрмөсөн алдана.

АРВАН ХОЁР. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 12.1 Энэ гэрээ болон түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар талуудын хооронд маргаантай асуудал үүсвэл эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ;
- 12.2 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Санхүүгийн зохицуулах хороонд, хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН ГУРАВ. БУСАД

- 13.1 Талууд гэрээ, түүний хавсралтад харилцан тохиролцож зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт бүр нь гэрээний салшгүй хэсэг байна. Нэмэлт өөрчлөлтөд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөрт тооцно;
- 13.2 Эрх бүхий байгууллагаас шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг нэг дахин нэмэгдүүлсэн хэмжээний өөрчлөлт оруулсан, шүүгч шинээр томилогдсон тохиолдолд ажлын 5 өдрийн дотор даатгагчид мэдэгдэж гэрээ, түүний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулна;
- 13.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд хамтарсан комисс байгуулж гэрээг дүгнэнэ;

- 13.4 Гэрээг дүгнэсний дараа даатгалын нөхөн төлбөр даатгалын хураамжийн үнийн дүнд хүрээгүй зөрүү үүссэн тохиолдолд даатгагч тал даатгалын жилийн хураамжаас үлдсэн хэмжээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээгээр даатгуулагч талын албан хаагчдыг гадаад болон дотоодын эрүүл мэндийн байгууллагад оношилгоо шинжилгээ, эмчилгээ хийлгэх, эрүүл мэнд сэтгэл зүйн нэмэлт үйлчилгээ үзүүлэх ажиллагааг санхүүжүүлнэ.
- 13.5 Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээг хоёр хувь үйлдэн, талууд хувийг хадгална.

АРВАН ДӨРӨВ. ХОХИРЛЫН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- 14.1 Гэмтэл бэртэлтэй холбоотой гэнэтийн ослын үед авах арга хэмжээ
- 14.1.1 Хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой нөхцөл байдлын үед шаардагдах түргэн тусламжийг яаралтай үзүүлэх, түргэн тусламж, холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэх
- 14.1.2 Даатгалын тохиолдол болсон газар боломжтой бол:
- 14.1.3 Холбогдох баримт нотолгоо болох эд зүйлийг шинжлэн дүгнэх, шуурхай албаны хүмүүс иртэл хөндөхгүй, хэвээр байлгах;
- 14.1.4 Түүнд оролцсон болон гэрчийн мэдүүлгийг үнэн зөвөөр авах;
- 14.1.5 Тохиолдол болсон цаг хугацаа, газар орон, хэн бэртэж гэмтсэн, нас барсан, ямар зүйл хохирсон талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- 14.1.6 Хохирол учирсан тухай бүрд даатгагчийн Шуурхай албанд мэдэгдэж байх;
- 14.2 Хохирол, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авах, шийдвэрлэх, даатгалын тохиолдлын үед түргэн шуурхай ажиллах 24 цагийн дуудлага хүлээн авах үүргийг даатгагчийн Шуурхай Алба гүйцэтгэнэ.
Шуурхай албаны утас:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

.....

.....